



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.07.16, ДАВАА ~ №137 (936)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Google Duplex хиймэл оюуны туршилт эхэллээ

Хиймэл оюун энэ зунаас ресторанд ширээ захиалж үсчинд цаг авдаг болно. > 4

FT Бизнес, эдийн засгийн төрөлжсөн сувар Financial Times-ийн нийтлэлүүдийг албан ёсны эрхтэйгээр хүргэж байна.

Криптовалютын талаарх СЗХ-ны байр суурь хэвээрээ гэв

Криптовалют нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулиар зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа. > 5

Biography of Tavan Tolgoi residual coal deposits

Tavan Tolgoi contains 7.6 billion tons of coal reserve according to JORC. > 6

ОНЦЛОХ

УЛС ТӨР
ЕТГ-ын дарга З.Энхболд Режеп Тайп Эрдоаны "Ерөнхийлөгчийн албан тушаалдаа орсны ёслол"-д оролцов.
Ээлжит бус чуулган хуралдуулахыг УИХ-ын 25 гишүүн дэмжиж, гарын үсэг зуржээ.
Ватиканы нууц архивт буй Ил-хан Абагагийн захидлын эх хувийг ЭС Ц.Жамбалдоржид үзүүлэв.
Төрийн өмчийн 51-ээс доошгүй хувийн оролцоотой "Тавантолгой төмөр зам" компани байгуулна.
ЭДИЙН ЗАСАГ
Монголын хөрөнгийн биржийн арилжаанд гар утаснаасаа оролцох боломжтой болно.
Fitch агентлаг Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В" болгон дээшлүүлэв.
Улсын хэмжээнд энэ онд 1.1 сая тонн газрын тос олборлож, экспортлоно.
Гадаад валютын албан нөөц 2017 онтой харьцуулахад гурав дахин нэмэгдэж, 3.3 сая ам.долларт хүрэв.

НИЙГЭМ
Хорио зөрчин шүлхийн бүс нутагт зорчсон 46 иргэнд 6.1 сая төгрөгийн шийтгэл ногдуулжээ.
Монголын баг ОУ-ын математикийн олимпиадаас нэг мөнгө, таван хүрэл медаль хүртэв.
Дэлхийн Инновацийн индексээр Монгол Улс 126 орноос 53-т жагслаа.
Хүүхдийн сурын харваанд дөрвөн настай хүү тавдугаар байр эзэлжээ.

ДЭЛХИЙ
Хятад улс АНУ-аас импортлох шар буурцгийн хэмжээг 11 хувь багасгах төлөвтэй байна.
Оросууд Ираны эрчим хүчинд 50 тэрбум ам.доллар оруулахаа мэдэгдэв.
Пакистаны Ерөнхий сайд асан Наваз Шарифыг авлигын хэргээр баривчилсан байна.
ОХУ ДАШТ-ий дараа хөл бөмбөгийн стадионуудыг ашиглах арга замыг хайж эхэлжээ.
АНУ-ын Холбооны нөөц америкчуудын ажиллах идэвх нэмэгдсэнийг мэдээлжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
 2018.07.16

 24° | 12°
ТҮР ЗУУРЫН БОРООТ

 Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

ХЭНЭГГҮЙ ЗАН-ХҮҮХДИЙН ОСЛЫН ГОЛ ШАЛТГААН



Сүүлийн хоёр жил хагасын хугацаанд 51 хүүхэд усанд осолдож амиа алджээ. Эцэг, эхчүүд аминаасаа илүү харж хандах учиртай алаг үрсээ хайхардаггүй нь энэ бүх осол эндэгдлийн шалтгаан болж байна. ▶ 3

УЛСТӨР
О.Баасанхүү: МАХН-аас С.Ганбаатар, Н.Энхбаяр нар дэвшихгүй

Б.Энхжаргал
 @enkhjrgjZGM

УИХ-ын гишүүн О.Баасанхүүтэй ярилцлаа. Хаврын чуулганы үр дүн, Хэнтийн 42 дусаар тойргийн нөхөн сонгууль, МАХН-ын дотоод асуудал зэрэг олон сэдвээр түүний байр суурийг сонирхсон юм.

-УИХ-ын хаврын чуулган завсарлалаа. Энэ удаагийн

ээлжит чуулганы үр дүнг та хэрхэн үнэлж байгаа вэ?

-2016 оны сонгуулийн үр дүнгээр МАН 65 суудал авсан. Үнэмлэхүй олонхид сайн болон муу талын аль аль нь байдаг. Сайн тал нь томоохон шийдвэрийг улс орныхоо төлөө зоригтой гаргах боломж бүрддэг. Муу тал нь хэт зоригтой шийдвэрээ хэтрүүлчих гээд байдаг учраас сөрөг хүчний хагуу хяналт хэрэгтэй.

▶ 2

Өрийн өсөлт шинэ зах зээлийг түгшээв

Жонотан Уитли

Гуравдугаар сар хүртэл жилийн хугацаанд дэлхий даяар өрийн хэмжээ 25 их наяд ам.доллараар өссөн бол 2018 оны эхний нэг улиралд найман их наядаар дээшилснийг Олон улсын санхүүгийн хүрээлэн мэдээллээ.

Түүнчлэн ДНБ-д харьцуулсан өрийн хэмжээ мөн адил нэмэгдэж, 318 хувьд хүрсэн нь 2016 оны гуравдугаар улирлаас хойш анх удаа ийм өндөр үзүүлэлттэй гарчээ. Энэхүү өөрчлөлтийн хурдац хийгээд хэмжээ дэлхийн санхүүгийн системд аюул учруулахуйц болсон нь сэтгэл түгшээж буй. Үүний сацуу АНУ-ын бодлогын

хүү дээшилж, ам.доллар чангарсан явдал зээлдэгчдэд эрсдэл үүсгэсний дээр дэлхийн өсөлт саарч байна. Шинэ зах зээлүүдийн хувьд ийм аюул илүү хүндээр тусна.

Дэлхийн санхүүгийн хямралын дараах арван жилд АНУ-ын Холбооны нөөц болон бусад банкууд хэт сул мөнгөний бодлого явуулсан нь шинэ зах зээлүүдэд асар их мөнгийг шахаж оруулсан юм. Allianz банкны гол зөвлөх Эл-Эриан "Капитал асар ихээр орж ирэх үед болгоомжтой байх ёстой. Ирээдүйн хямралын үрийг суулгах эрсдэл дагуулж болзошгүй" хэмээв.

▶ 7

ЭДИЙН ЗАСАГ
Зүүн өмнөд Ази ханшаа хамгаалж эхлэв


Г.Байгал
 @baigalZGM

Дэлхийн мөнгөний салхи эргэлээ. Мөнгөний зах зээлийн луужин болдог томоохон төв банкууд жанжин шугамаа өөрчилж, бодлогын жолоогоо татаж байна. Гэхдээ АНУ, Англи, Япон, Европын төв банкууд сүүлийн 10 жил замнасан бодлогоосоо нүд ирмэхийн зуур ухарсангүй. Харин аажим, алгуурхан бодлогын хүүгээ өсгөж эхэллээ. Ийнхүү мөнгөний бодлогын салхи эргэж буйтай зэрэгцээд үйлдвэрлэлийн үнээс өрхийн төсвийг хүртэл хөнддөг газрын тосны ханш чангарсаар.

Хоёр жилийн өмнө 20-30 ам.доллар хүртлээ буурч байсан түүхий газрын тосны ханш хэд дахин өсөж, өдгөө 80 ам.долларт хэлбэлзэж байна. Ийнхүү бараа үйлчилгээний үнэ, ам.доллараар ахлуулсан голлох валютын ханш чангархтай зэрэгцээд хөгжиж буй орнуудын рупи, баг зэрэг мөнгөн

тэмдэгтийн ханш суларч эхэллээ. Ялангуяа, Холбооны нөөцийн банк тэгтэй ойр байсан бодлогын хүүгээ хоёр хувь хүртэл өсгөж, цаашид ч нэмэгдүүлэхээ мэдэгдээд байгаа энэ үед Зүүн өмнөд Азийн орнууд валютын уналттай нүүр тулчихаад байна. Тиймээс мөнгөн тэмдэгтийн ханшийг хамгаалах аянд бүс нутгийн орнууд нэгдэж, бодлогын чиглэлээ эрс өөрчилж эхлэв.

▶ 5



АЛТ 1251.19 0.25%	ЗЭС 6237 0.14%	10-ЧИНГИС БОНД 94.50 0.14%	ХУРАЛДАЙ БОНД 95.21 0.15%	ГЭРЭГЭ БОНД 108.32 0.13%	АМ.ДОЛЛАР 2461.66	ЮАНЬ 372.02	РУБЛЬ 39.43
--------------------------------	-----------------------------	---	--	---------------------------------------	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

УЛСӨРЧ ЯРЬЖ БАЙНА

О.Баасанхүү: МАХН-аас С.Ганбаатар, Н.Энхбаяр нар дэвшихгүй

Үндсэн хуулийн өөрчлөлтийг нэг хувь нь л эсэргүүцэж байвал битгий батал

◀1

Харамсалтай нь, өнөөгийн олонхийг бүрдүүлж буй 65 гишүүн дотроо хуваагдаад, санасан үр дүнд хүртэл ажилласангүй. Үүнд би их харамсаж байгаа. Жишээлбэл, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Үндсэн хуулийн зарим заалт, Сонгуулийн тухай хууль, Татварын ерөнхий хууль гээд олон асуудалд шинэчлэл, өөрчлөлт хийж ёстой байсан. Гэвч алийг нь ч хийсэнгүй. Гэсэн атлаа телевизээр элдэв худлаа сурталчилгаа хийхээс өөр үр дүнтэй ажлыг энэ УИХ болон Засгийн газар хийсэнгүй.

-Хаврын чуулганы төгсгөлд нэлээн том асуудлууд орж ирсэн. Төмөр зам, Тавантолгой орд зэрэгтэй холбоотой хэд хэдэн шийдвэр гарсан шүү дээ.

-Монгол Улс бүх зүйлээ зарж байна. Үүнийг Ерөнхийлөгч асан П. Очирбатын үеэс эхлэлтэй гэж хэлж болно. Газрын тосны ордоо ашиглуулах гэрээний заалтаа аятайхан хийчихсэн бол өнөөдөр Монгол Улс боловсруулах үйлдвэртэй болчих байлаа. Гэвч хятадуудад зүгээр л өгчихсөн. Бүхэл бүтэн 25 жил Монголын нефтийг зөөж байж, орон нутагт нь засмал зам ч тавиагүй. Саяхан Ерөнхий сайд газрын тос боловсруулах үйлдвэрийн шав тависан талаар зурагтаар гарч байсан. Гэхдээ түүхий эдээ хаанаас авах вэ. Одоогийн газрын тосны тухай хуулиар “Петро Чайна Дачин Тамсаг”-аас авч болохгүй. Дараа нь Монгол Улс арай гэж эзтэй болсон. Гэтэл Фрийдланд гэдэг нөхөрт бас л Монголд

ашиггүй байдлаар өгчихсөн. Харин ч эсрэгээрээ Фрийдланд нь Монгол Улсыг арван тэрбум ам.долларын өртэй болгосон. Энэ ажлыг Монголын гурав дахь Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Н.Энхбаяр хийсэн. Харин одоо төмөр замыг оросуудад өгөхөөр болчихлоо.

-Төмөр замыг Оросод өгөх гэж байна гэж та ямар үндэслэлээр хэлж байгаа юм бэ?

-Бодлогыг нь уншихад л ойлгоно. Монгол Улс ШХАБ-д элсэх тухай идэвхтэй ярилаа. Тэгэхдээ ШХАБ-д элсэнэ гэдэг Оросын талыг баримтлах уу, Хятадыг дагах уу гэдэг л асуудал юм. Хятадыг баримталж орвол эдийн засгийн асуудлыг ярих байх. Харин Оросыг дагавал Варшавын гэрээний орон гэдэг шиг цэрэг зэвсгийн эвсэл болох л сонирхол юм. Тиймдээ ч ОХУ-д хадаг бариад явж байна. Ийм л зөрчилтэй гадаад бодлого, удирдлага, байр суурь Монгол Улсыг тодорхойгүй байдалд оруулж байгаа юм.

-Хаврын чуулганы төгсгөлд Захиргааны ерөнхий хуулийг өөрчлөх асуудлыг Засгийн газраас оруулж ирсэн нь ихээхэн маргаан дагуулаа. Та хуульч хүний хувьд энэ хуулийн төслийн талаар ямар бодолтой байна вэ?

● **Харамсалтай нь, өнөөгийн олонхийг бүрдүүлж буй 65 гишүүн дотроо хуваагдаад, санасан үр дүнд хүртэл ажилласангүй.**

● **Төрийн алба улс төрөөс хараат бус гэдгээ Үндсэн хуульдаа тусгаад өгчих.**

● **Н.Энхбаяр, С.Ганбаатар нар бие дааж нэр дэвшинэ биз. Тэдэнд МАХН-аас нэр дэвших ямар ч боломж байхгүй.**

-Нэг талаасаа шүүгч нар нь бүтэхгүй хүмүүс байна. Нөгөө талаасаа шүүгчээс болж шүүх засаглалыг самраа гэж байгаа. Хууль зүйн сайд бүр ч бүтэхгүй. Тэр хүн өөрөө энэ салбарын сайдаар 20 жил ажилласан.

Хууль зүйн салбарын удирдлагаар ажиллаж байгаа бүх хүн өөрийнх нь дүү нар. Өөрөө л дэслэгчээ генерал хүртэл хөтлөөд явсан. Шүүгчийн туслах байхаас Дээд шүүхийн дарга болтол нь дагуулж явсан хүн бол Хууль зүй, Дотоод хэргийн сайд Ц.Нямдорж. Ингэж явахдаа хүмүүсийг барьцаалж, дарамталж байгаагүй юм бол юундаа айдаг юм. Хууль зүйн салбарыг удирдаж байгаа, өмнө нь 20 жил удирдсан хүн шударга ёсыг тогтоож чадахгүй байгаа бол би бүр ч чадахгүй. Ард түмэн бол ярих ч юмгүй болох нь. Хууль, шүүхийн салбар болж бүтэхгүй байна гэж гомдох эрхгүй хүн бол Ц.Нямдорж сайд юм.

-Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг УИХ-аас гарсан Ажлын хэсэг бэлэн болгосноо танилцуулсан. Таны гар дээр хуулийн төсөл ирсэн байх. Үндсэн хуульд оруулж буй өөрчлөлтүүдийн талаар ямар бодолтой байна?

-МАН, АН, Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад би ганц л зүйл хэлдэг. “Үндсэн хуулийг өөрчлөхөд 99 хувийн дэмжлэгтэй ч нэг хувийн эсэргүүцэлтэй л байвал битгий батал” гэж.

Гадныхны гар хөлөөр Өмнөговь, Ховд, Баян-Өлгий зэрэг аймгийг Монгол Улсаас салан тусгаарлуулах янз бүрийн бодлого явдаг юм байна. Украин шиг улс



С.Батсайхан / ЗГМӨ

дотор нь нийгэм, эдийн засгийн цөхрөө өгөөд, хямрал үүсгэхийг гэдгээс болгоомжлох ёстой. Ленинээс жишээ авахад Германаас мөнгө авч ирээд л Хаант Оросод хувьсгал хийж байсан. Үндсэндээ тэр нь хувьсгал биш хядлага байсан юм. Өөрөөр хийлбэл, өшөө хорслоо тэгж тайлсан гэсэн үг. Яагаад гэвэл Хаант Оросын засаг төрсөн ахыг нь хөнөөчихсөн учраас Ленин нярай хүүхдийг хүртэл цаазалж байсан хүн. Харин түүний ах нь одоогийнхоор бол террорист л байсан байхгүй юу. Түүн шиг гадаадад байгаа хүмүүс Монголд ирээд Үндсэн хуулиар далимдуулж үндэстний тусгаар тогтнолыг алдагдуулах, өөрийн шуналаа хангах гээд байна. Тиймээс миний дээр хэлсэн субъектууд 100 хувь дэмжиж байгаа гурван заалт л байгаа. Түүнийг батлаад бусдыг нь оролдох зэрэггүй.

-Тэр гурав нь яг ямар заалт юм бол?

-Сонгууль бүрийн дараа ялсан нам нь өмнө нь ажиллаж байсан төрийн албан хаагчдыг халаад өөрсдөө томилгоо хийдэг. Тиймээс төрийн алба улс төрөөс хараат бус гэдгээ Үндсэн хуульдаа тусгаад өгчих. Хоёрдугаарт, хотын асуудал. Бид хотожсон, суурин нийгэмтэй байга гэж байгаа бол Үндсэн хуульдаа хотын статусыг оруулчих. Харин эцэст нь сонгуулийн тогтолцооны асуудал. Монгол Улс ардчилсан хувьсгалаас хойш 28 жил сонгууль явуулаа. Тэгэхдээ 6-7 удаа сонгуулийн хуулиа өөрчилсөн байдаг. Тиймээс Үндсэн хуульдаа сонгуулийн тогтолцоогоо суулгаад өгчих. Эхний жилдээ тэр хуулийг баталсан эрх баригчид нь ялаг. Харин дараа дараагийн сонгуульд дүрэм нь тодорхой юм чинь бусад намууд ялна. Тэгэхгүй бол ялсан нам нь дараагийн сонгуульд яаж дахин амьд үлдэх вэ гэдгээ тооцож, сонгуулийн тогтолцоог боловсруулаад байна.

-МАХН-ын дотоод зөрчил юу болсон бэ. УДШ дээр та болон Н.Энхбаяр дарга тус тусдаа намын дүрмийн болон даргын шинэчлэлтэй холбоотой бичиг өгөөд байгаа. Энэ асуудал шийдэгдсэн үү?

-Намд дүрэм бий. Бага хурал гэж бий. Бага хурлын 139 хүний 104 нь намын их хурлаа хийгээд Н.Энхбаяр даргыг намын дарга болгоё гэсэн. Гэтэл Н.Энхбаяр гэдэг хүн “Нам бол би. Дүрэм гэдэг би. Мөнгө гэдэг би” гэж хэлээд Бага хурлын шийдвэрийг зөвшөөрөөгүй. Тэгээд өнөөдөр ээлжит бус их хурал хийнэ гээд ярьж явна. Мөн намын Бага хурлаас УИХ-ын сонгуульд хүнээ дэвшүүлдэг.

-Тэгэхээр удахгүй болох Хэнтгийн нөхөн сонгуульд Бага хурлын шийдвэрээр нэр дэвшигч тодорно гэсэн үг үү?

-Н.Энхбаяр гэдэг хүн өөрөө ч дэвших юм шиг, С.Ганбаатарыг

дэвшүүлэх ч юм шиг зүйл яриад яваад байгаа. Дур эзэнээ голохгүй, дунд чөмөг сүүжээ голохгүй гэдэг шиг л юм болж байна. Гэхдээ Бага хурлын 104 гишүүн эсрэг байр суурьтай байгаа. Тэдэнтэйгээ эхлээд учраа олж, уучлалт гуйх ёстой. Мөн албан тушаал, намын даргын тамгаа өг. Арав гаруй жил төрийн өндөр дээд албан тушаалд ажиллаж, дараа нь нам

удирдаж яваа хүн. Одоо болно гэж Н.Энхбаяр даргад хэлэе. Ямар ч байсан дүрмийн дагуу Бага хурлын гишүүд намын даргаас илүү эрх мэдэлтэй байдаг.

-Тэгэхээр Хэнтгийг Н.Энхбаяр, С.Ганбаатар хоёрын хэн нэгэн нь дэвшлээ гэхэд Бага хурал дэмжээгүй гэдэг шалтгаанаар СЕХ бүртгэхгүй байх асуудал үүсэж болох нь ээ?

-Тийм. Манай Бага хурлын гишүүд лав дэмжихгүй. Бид өөр хүн дэвшүүлнэ.

-Хэнийг?

-“Хасу Мегавайт” компанийн хүн байгаа. Сая манай намаас хийсэн судалгаагаар тэр хүн бусад нэр дэвших магадлалтай бүх хүнээс илүү өндөр рейтингтэй байсан.

Хууль зүйн салбарын талаар гомдол хэлэх эрхгүй хүн бол Ц.Нямдорж сайд

-Та нэрийг нь хэлж болох уу. Тус компанийн захирал юм уу?

-Эхний ээлжинд Хэнтгид ажилладаг хүн гэдгийг нь л хэлэе. Тэр нутгийнхан бол андахгүй. Ямар ч байсан бид тэр хүнтэй очиж уулзана.

-Тэгэхээр өөрөө нэр дэвших саналаа та бүхэнд хэлээгүй гэсэн үг үү?

-Хэлээгүй. Бид хадаг барьж очих гээд байна. Яагаад гэвэл бидний хийсэн судалгаагаар тэр хүн бусдаасаа хамаагүй өндөр рейтингтэй гарсан байгаа. Харин Н.Энхбаяр, С.Ганбаатар нар бие дааж нэр дэвшинэ биз. Тэдэнд МАХН-аас нэр дэвших ямар ч боломж байхгүй. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА-2

Огноо : 2018.07.16

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Удирдлагын нэгдсэн төвийн барилгын гадна цахилгааны шугам сүлжээний угсралтын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах-2.
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-АУ-2018-86

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос **Удирдлагын нэгдсэн төвийн барилгын гадна цахилгааны шугам сүлжээний угсралтын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендер** ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянган/** төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ. Сүүлийн 2 жилд буюу 2016, 2017 онуудад ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ. Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2016, 2017/ тус бүр тухайн ажлын төсөвт өртөгөөс дээш байх.

Тендерийн хамт **7,600,000 /долоон сая зургаан зуун мянган/** төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: 2018 оны 10 дугаар сарын 28-ны өдрийг дуустал.

Тендерийг **2018 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 10 цаг 30 минут**-аас нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157018-223

ТЕНДЕРИЙН УРИЛГА-2

Огноо : 2018.07.16

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Ус сувгийн удирдах цагаан давс нийлүүлэгчийг сонгон шалгаруулах-2.
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: УСУГ-БМ-2018-109

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос **Цагаан давс нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай битүүмжилсэн тендер** ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянган/** төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно.Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Сүүлийн 2 жил 2016, 2017 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ. Сүүлийн 2 жилд 2016, 2017 онд ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ. Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил тус бүр төсөвт өртгийн 80%-с дээш байх.

Тендерийн хамт **2,200,000 /хоёр сая хоёр зуун мянган/** төгрөгийн баталгаа ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: 2018 оны 10 дугаар сарын 28-ний өдрийг дуустал.

Тендерийг **2018 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 14 цаг 00-аас** өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 14 цаг 30 минут**-аас нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар Утас: 70157019-223

[ЗГМ СӨНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТҮЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энжжаргал
Утас: 99901621

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртөгтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА


Утас: 99903581
99903578
99909472
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР
ubinfo.mn

Дугаарын удирдагч
Б.Энжжаргал



86638000429112 00936

Нийтлэлчийн булан

Хэнэггүй занд ухамсар суулгахын тулд хэчнээн үрс хорвоог орхих ёстой бэ

З.Цэлмэг
@tselmegZGM

Баяр наадмын өмнөхөн бага насны хүүхдүүд бараг өдөр дараалан цаг бусаар өөд болсон. Тэдний араас олон нийтийн сүлжээгээр сүртэй нь аргагүй халаглаж байсан харуусал, эмгэнэл баяр наадмын хөл хөөрцөгт дарагдаж, монголчууд нүдээ аньж, чихээ бөглөөд хэд хоног сайхан наадлаа. Эмгэнэлтэй нь энэ их баяр хөөрийн дунд дахин нэг хүүхэд усанд осолдож хорвоог орхив.

Аав, ээжийнхээ гараас хөтлөөд, шулганаад явдаг насан дээрээ усанд осолдож, нас барсан хүүхдийн тоо он гарснаас хойш 10 болоод байна.

Өнгөрсөн бямба гарагт Туул голд дөрвөн настай эрэгтэй хүүхэд осолдож нас барсан бол зургадугаар сарын 27-нд мөн Маршалын гүүр орчимд 10 настай эмэгтэй хүүхэд усанд живж амиа алдсан харамсалтай тохиолдол гарсан.

Цагдаа болон онцгой байдлын газраас дулааны улирал эхлэнгүүт иргэдэд үер уснаас болгоомжлохыг анхааруулж, хэвлэл мэдээллийнхэн ч түүнийг нь эрвийх дэрвийхээрээ мэдээлдэг. Мөн аврах албаныхан зуны турш эргүүл хийж, дуудлагаар үйлчилдэг ч осол эндэгдэл багасах янз огт алга. Наадмын өмнөхөн, үерлээд улаанаар эргэлдэж буй Хэрлэн голын эрэг дээр 2-3 хүн жижиг, том нийлсэн зургаан хүүхдээ тэр чигт нь мартаж, гар утсаа маажалд хэвтэж байхтай таарав. Ач, эзэгнэ дагуулаад явж байгаа болов уу гэмээр нас тогтсон хүмүүс харагдсан, уг нь. Гэвч хараажаар үертэй, эрэг нь огцом Хэрлэн гол үр, хүүхдийг минь урсгаад аваад явчих вий гэсэн анхаарал болгоомж тэдэнд алга. Хүүхдүүдийн хамгийн том нь 10-12 насных, бага нь хөлд ороод удаагүй бололтой тэнтэр гунтар алхах нь юу юугүй л эрэг рүү хальтраад орчих вий гэмээр эв хавгүй харагдсан. Бидний хэдэн нөхөд хүүхдүүдийг хараад тайван сууж чадахгүй, гол руу хамаагүй ойртож болохгүй шүү



Оны эхний хагас жилийн байдлаар усанд осолдож, халуун амиа алдсан таван хүн тутмын нэг нь хүүхэд байна.

Б.Батдорж / ЗГМӨ

Хэнэггүй зан-хүүхдийн ослын гол шалтгаан

гэдгээс өөрөөр болгоомжлуулах учраа олоогүй юм. Хэдийгээр хүүхдүүд аюулд ойрхон байсан ч аз болж тэдэнд муу зүйл тохиолдоогүй.

Гэвч сониуч зандаа хөтлөгдөн голд осолдсон хүүхдийн тоо жилд 10, 20-оор тоологддог. 2016 онд 25, 2017 онд 16 хүүхэд усанд осолдон нас барсан нь ЦЕГ-ын статистикт бий. Харин оны эхний хагас жилийн байдлаар усанд осолдож, халуун амиа алдсан таван хүн тутмын нэг нь хүүхэд байна. Долдугаар сарын 13-ны байдлаар усны ослын тохиолдол 12 аймгийн 27 сум, нийслэлийн дөрвөн дүүрэгт 39 удаа гарч, 48 хүн амиа алдсаны ес нь хүүхэд, 39 нь насанд хүрэгсэд байгаа талаар ОБЕГ мэдээллээ. Иргэдийн анхаарал болгоомжгүй байдал, бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхих, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гол усанд орсноос осолдог гэдгийг ОБЕГ анхааруулдаг. Ерөөс тус газарт хандаж буй иргэдийн дуудлагын дийлэнхийг усанд осолдсон

● **Сониуч зандаа хөтлөгдөн голд осолдсон хүүхдийн тоо жилд 10, 20-оор тоологддог.**

● **2016 онд 25, 2017 онд 16 хүүхэд усанд осолдон нас барсан.**

● **Аминаасаа илүү харж хандах учиртай алаг үрсээ мартаад байгаа нь энэ бүх осол эндэгдлийн шалтгаан болжээ.**

тохиолдол эзэлдэг байна. Иргэд анхаарал болгоомжоо дээшлүүлэхгүй, үр хүүхдээ голын эрэг дээр мартаж, өөрсдөө зугаацаж, биеийн амрыг харж хэвтдэг байдал өөрчлөгдөхгүй байгаа нь юутай харамсалтай.

Монголд хүүхэд эндэх олон шалтгаан бий. Эхийнхээ хэвлийд хүн болж чадаагүй нь жилд 500 хүрч байгаа бол таван нас хүртлээ 1300 гаруй нь энддэг гэх эрүүл мэндийн статистик бий. Эдний тэн хагасаас илүү нь нэг хүртэлх насандаа амьсгал болон мэдрэлийн тогтолцооны эмгэг, төрөлхийн гажиг, ходоод гэдэсний өвчнөөр хорвоог орхидог аж. Харин үлдсэн нь золгүй байдлаар эндэж байгаагийн дийлэнх нь эцэг, эхийн хараа хяналтгүй байдлын хар гай, ээлгүй орчны балаг гэлтэй. Тухайлбал, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн Түлэнхийн тасагт жилд 0-5 насны 2500 гаруй хүүхэд түлэгдэлтийн улмаас яаралтай түргэн тусламж авч эмчлүүлдэг. Үүний 80 хувь нь халуун тогоонд түлэгдсэн байдаг бөгөөд энэ бол цэвэр эцэг, эхийн хариуцлагагүй байдалтай холбоотой гэдгийг нийслэлийн Цагдаагийн газрын ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч А.Батсүх хэллээ. Тэрбээр "Цагдаа

болон холбогдох байгууллага эрвийх, дэрвийхээрээ хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгаа явуулж байна. Гэвч нөгөө талаас хүүхдийн аюулгүй байдлыг тэдний хууль ёсны асран хамгаалагч болох эцэг, эхийн хариуцлагаас салгаж ойлгох аргагүй" гэв.

Түүнчлэн энэ жилийн баяр наадмаар нийслэлийн хэмжээнд, наадмын тайлбайд 64 хүүхэд төөрч, алга болсныг цагдаагийн алба хаагчид олж, эцэг, эхэд нь хүлээлгэж өгсөн. Мөн орон нутгийн замд гарч буй осол, унаач хүүхдүүдийн бэртэл гэмтэл, эцэг, эхчүүд голын эрэгт үр хүүхдээ умартан, зугаацаж цэнгэхээ урьтал болгодогос "Цагаан сар ба хар нулимс"-тай адил эмгэнэлт хувь тавилан найр наадам ид хавтгайрсан зуны дэлгэр цагт монголчуудад тохиолддог бололтой.


Томчууд бид гар утас зэргээ гэртээ мартсанаа, машинаа зөвшөөрөөгүй газар зогсоовол

ачуулдаг гэдгийг мэддэг, гэвддэг атлаа аминаасаа илүү харж хандах учиртай алаг үрсээ мартаад байгаа нь энэ бүх осол эндэгдлийн шалтгаан болжээ. Хатуудсан зэмлэл гэж үүнийг буруушаах нэгэн үгүй биз.

Амарч зугаалж, баясаж цэнгэхээр гараад үр хүүхдээ үүрд алдаж, цангинасан инээдийг нь дахиж сонсохгүй, булбарай гарнаас нь хэзээ ч хөтлөхгүй болохоос илүү хагачал гэж энэ хорвоод үгүй. Хүүхэд бол гэнэн томоогүй, сониуч, анхаарал болгоомжгүй гэдгийг бид бүхэн мэдэхийн дээдээр мэднэ. Тиймээс ч тэднийхээ эрүүл энх, аюулгүй байдлыг хангах нь бидний журамт үүрэг болохоос биш цагдаа, хүчнийхнээр заалгаад байж таарахгүй. Тэгэвч ийм болтлоо ухамсар доройтсон нь юутай гачлантай. Өврөөсөө ч гарч амжаагүй өөдөсхөн үрсээ үл тоодог хэнэггүй занд хариуцлага нэхэх ухамсар суулгахын тулд хэчнээн үрс хорвоог орхих ёстой юм бэ. [ЗГМ]


УХААРАЛ ХАЙРЛАХ УРАН ШОГ

Нэгэн айлын хөг



Херлуф Бидstrup

Технологи



Google Duplex хиймэл оюуны туршилт эхэллээ

Хиймэл оюун энэ зунаас ресторанд ширээ захиалж үсчинд цаг авдаг болно

Г.Очир
ЗГМ

Google компани АНУ-ын Калифорни мужийн Маунтин Вью дахь ресторанд цугласан сэтгүүлчдэд сайжруулсан Duplex технологио танилцуулаа. Google Duplex нь гар утас хэрэглэгчийн өмнөөс ресторанд ширээ захиалж, үсчинд дугаар авах чадвартай, хиймэл оюунд тулгуурлаж ажилладаг дуут туслагч. Туршилтад байлцсан сэтгүүлч бүртэй хиймэл оюун ухаан утсаар холбогдож, захиалга хийхээр оролдсон байна.

Туршилтыг ердөө хэдхэн долоо хоногийн дараа ердийн хэрэглэгчдийн дунд эхлэх гэж байгааг Google Assistant-гийн маркетинг хариуцсан дэд ерөнхийлөгч Ник Фокс мэдэгдлээ. Эхний ээлжинд туршилтыг Google-тэй хамтран ажилладаг цөөн байгууллага, хэрэглэгчдийн хязгаарлагдмал хүрээнд үе шаттай явуулна.

Duplex нь юун түрүүнд хэрэглэгчид асуулт тавих дуудлагыг ажлын бус цагаар хийж сурах ёстой. Дараа нь энэ зунаас ресторанд ширээ захиалж, үсчинд дугаар авдаг болно. Одоогоор Google компани ердөө энэ гурван ажилд Duplex-ийг дадлагажуулахаар хичээж байна.

Технологийн The Verge сайтад мэдээлсэнээ үзвэл хиймэл оюуны дуу хоолой хүнийхтэй тун төстэй, “Аанхаа”, “Унн” гэх мэт аялга үг хүртэл хэлж байгааг сэтгүүлчид онцлон дурджээ. Мөн хиймэл оюунаас залгах дуудлага бүрийг бичиж байгаа гэдгийг урьдчилан

сануулж явна. Жишээ болгон нэг дуудлагыг сонирхвол: “Сайн байна уу? Захиалга өгөхөөр тань руу залгаж байна. Би бол Google-ийн автомат захиалгын үйлчилгээ учраас энэ дуудлагыг бичиж явах болно. Ням гарагийн өглөө ширээ захиалж болох уу?”.

Google компани хүмүүс автомат дуудлагатай хэрхэн эвтэй ярилцаж болох вэ гэдгийг тодорхойлсны үндсэн дээр дуу хоолойны өнгийг засан сайжруулж явах юм. Мөн ойлгомжтой байх үүднээс яриаг бичиж байгааг сануулсны дараа робот түр “ммм” гэх мэт завсарлага авч байгаад захиалга өгнө. Duplex-ийг анх турших үед дуу хоолой хүнийхтэй төсгүй байснаас амжилт олоогүй. “Яриаг сонсож дуусгалгүй утсаа тавьчих нь олон гардаг байлаа. Дэндүү хиймэл хоолой хүмүүст таалагдаагүй хэрэг” хэмээн Google Assistant-ийн инженеринг хариуцсан дэд ерөнхийлөгч Скотт Хоффман дурсав.

Техас зэрэг Google зөвшөөрөл авч амжаагүй цөөн хэдэн муж улсыг эс тооцвол Duplex-ийн туршилт удахгүй нийт АНУ даяар эхэлнэ. Одоогоор зөвхөн англи хэлээр хөгжүүлж буй Duplex-ийг газар газрын аялга, нарийн өргөлт зэргийг уг системд ойлгуулахаар Google-ийн хөгжүүлэгчид чармайж байна.

Одоогоор Duplex хүний ярианы өнгийг тун ч дажгүй ойлгож байна. Ярилцагч хүний хоолойны өнгө гайхсан, дургүйцсэн шинжтэй болох үед дуут туслагч хичээнгүй, маргалдаад байдаггүй үйлчлэгч дуурайн дуу нь үл ялиг уучлал хүссэн шинжтэй болж хувирна.

Одоогоор уг систем боловсронгуй бус хэвээр тул Duplex-ийн ойлгож чадахгүй байгаа бүх дуудлага яриаг Google-д илгээн дүн шинжилгээ хийж, хиймэл оюуны алгоритмыг төгөлдөржүүлэн сайжруулж явах юм. [ЗГМ]

Японы кинотеатрт виртуал бодит байдлын кино гарч эхэллээ



Охидын АКВ48 хамтлагийн дүү хамтлаг – STU48-ын гишүүд Токиод болсон хэвлэлийн хурлын үеэр VR кино үзэж байгаа нь

Sony-гийн харьяа Vaio корпораци VR буюу виртуал бодит байдлын киног Японы нийслэлийн Шинжюү дүүрэг дэх кинотеатрт долдугаар сарын хоёрноос эхлэн гаргаж эхэллээ. Персонал компьютерын бизнес эрхэлдэг Vaio нь бодит мэт визуал мэдрэмжийг кино театрын хүчирхэг аудио тоног төхөөрөмжтэй хослуулан хэрэглэх замаар VR зах зээлд бэхжүүлэхээр чармайж байна. Тус компанийн хүчин чармайлтын дүнд Японд VR кино дэлгэцнээ анх удаа гарч байгаа хэрэг боллоо. Эдүгээ VR технологийг ихэвчлэн видео тоглоом, сэдэвчилсэн паркуудын аттракционд түлхүү хэрэглэж байна.

VR нь нүдний тусгай шил зуусан үзэгчдэд киноны орчин нөхцөлд байгаа мэт санагдах гурван хэмжээст дүрслэл үүсгэж өгдөг юм.

Vaio, киноны Toei компанитай хамтран “Neon Genesis Evangelion” цуврал, нэрт манга зураач Фүжио Акацүкагийн бүтээл “Ososatsu Kun” зэрэг алдартай анимэ богино кино хэлбэрээр Shinjuku Wald есөн кинотеатр үзүүлэх юм. Тасалбарын үнэ 1500 иен буюу 13 орчим ам.доллар.

“Бид кинотеатрт кино үзэхийн утга учрыг ихэсгэх гэсэн юм” хэмээн Toei компанийн төлөөлөгч Хиденобу Мурамацү Токиод болсон хэвлэлийн хурал дээр тайлбарлав. [ЗГМ]

ОХУ хүний биед хөнөөлгүй хуванцар материал гаргаж авлаа



ОХУ-ын судлаачид анагаах ухаан, ялангуяа гэмтэл согог, мэс заслын салбарт асар ирээдүйтэй өвөрмөц материал гаргаж авлаа. Судлаачид хүний бие организмд аюулгүй “шингэдэг” био зохицол бүхий хуванцар бүтээж чадсаныг мэдээллийн ТАСС агентлаг уламжлав. Шинэ материалын ачаар жишээ нь гэмтсэн өвчтөний биеэс хожим сугалж авах шаардлагагүй тусгай бэхлэгч хийц үүсгэх боломж бүрдэж байна. Био зохицол бүхий уг хуванцарыг Москвагийн инженер-физикийн хүрээлэнгийн (МИФИ) харьяа Үндэсний судалгааны цөмийн физикийн их сургуулийн салбар, Балаковын инженер-технологийн хүрээлэнгийн

эрдэмтэд бүтээжээ. Судлаачдын бүтээсэн хуванцарыг хэдийн клиник туршилтад шилжүүлээд байна.

“Эрдэмтдийн бүтээсэн био зохицолт материал нь хүний бие махбодид дасан зохицох чадвартай. Жишээ нь хугархай яс холбосон ийм хуванцар бие мах бодь дотор уусаж, улмаар ясанд нэмэлт эрдэс тэжээл өгч бэхжүүлдэг тул хожим дахин мэс засал хийж авах шаардлагагүй” хэмээн судлаачид тайлбарлав.

Бие махбодь дотор уусах чадвартай хиймэл материалыг импортоор авдаг байсан ОХУ туршилт амжилттай болох тохиолдолд хэрэглээгээ дотоодын материалаар хангадаг болох юм. [ЗГМ]

Samsung уян ухаалаг утсанд зориулсан дэлгэц үйлдвэрлэнэ



Samsung компани Өмнөд Солонгосын Асане хот дахь дэлгэцийн үйлдвэрээ уян ухаалаг утас, таблетны дэлгэц үйлдвэрлэх туршилтын шугам болгон өөрчиллөө. Долдугаар сараас туршилтын загвар гаргаж эхлэх тус үйлдвэр 2019 оноос эхлэн жилдээ саяас доошгүй ширхэг уян дэлгэц зах зээлд нийлүүлнэ.

Одоогоор Samsung компани ухаалаг утас, таблетанд 7-8

инчийн уян дэлгэц ашиглахаар дизайныг сайжруулж байгаа юм. Өмнөд Солонгосын үйлдвэрлэгч уян дэлгэцтэй ухаалаг утсыг анх 2018 онд зах зээлд гаргахаар төлөвлөсөн. Гэвч технологийн хүндрэлээс шалтгаалан хойшуулжээ. Уян дэлгэц бүхий бүтээгдэхүүнийг тус компани 2019 онд Испанийн Барселонд болох Mobile World Congress (MWC) үзэсгэлэнгийн үеэр нийтэд танилцуулна. [ЗГМ]

КОНЦЕСС ОЛГОХ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо: 2018 оны 7 дугаар сарын 16-ний өдөр

Уралдаант шалгаруулалтын нэр: “Говийн бүсийн уул уурхайн төслүүдэд үйлдвэрийн технологийн ус нийлүүлэх төсөл”

Уралдаант шалгаруулалтын дугаар: УХГ/2013/317/443

Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар нь Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдлийг “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжих “Говийн бүсэд 120-155 мян.м3/хоног үйлдвэрийн ус нийлүүлэх, шугам хоолой барих төсөл”-ийн концесс олгох уралдаант шалгаруулалтад урьж байна.

Тус төслийн хүрээнд концесс авсан хуулийн этгээд, түүний нэгдэл нь өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр Говийн бүсэд 120-155 мян.м3/хоног үйлдвэрийн ус нийлүүлэх, шугам хоолойг барьж гэрээний хугацаанд ашиглана.

Концесс олгох уралдаант шалгаруулалтыг Концессын тухай хуулийн дагуу урьдчилсан болон уралдаант гэсэн 2 үе шаттай зохион байгуулна.

Оролцох санал гаргагчийн урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн дагуу ирүүлсэн оролцох саналуудыг үнэлж, урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн шалгуур үзүүлэлтүүдийг хамгийн сайн хангасан 4 хүртлэх оролцох санал гаргагчийг дараагийн үе шат болох уралдаант шалгаруулалтад оруулна.

Урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлтэй хуулийн этгээд, түүний нэгдэл шугам хоолой барих техник, технологийн чадвар, туршлагатай, тус ажлыг санхүүжүүлэх санхүүгийн чадвартай, концессын гэрээний хугацаанд тавигдсан шаардлага, нөхцөлийн дагуу шугам хоолойн засвар, арчлалт, үйл ажиллагааг найдвартай авч явах хүний нөөц болоод техник, технологийн чадвартай байна.

Урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг энэхүү урилгын дагуу төсөлд оролцох хүсэлтээ албан бичгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр баримт бичгийн үнэ болох 3 000 000 төгрөг /Банк: Төрийн сан, Хүлээн авагч: Үндэсний хөгжлийн газар, Данс: 100900008053/-ийг тушаасан баримтын хамт ирүүлсэн этгээдэд олгоно.

Урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 12.00 цагаас өмнө хүлээн авна.

Уралдаант шалгаруулалтад оролцогч нь шалгаруулалтад тэнцэн концессын гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд тус концессын төслийг хэрэгжүүлэх зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл бүхий хуулийн этгээд /төслийн компани/-ийг байгуулах шаардлагатай.

УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНАЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ:
Засгийн газрын тохируулагч агентлаг
Үндэсний хөгжлийн газар, Засгийн газрын II байр, 204 тоот. Утас: 261583

Эдийн засаг

МӨНГӨНИЙ БОДЛОГО

Зүүн өмнөд Ази ханшаа хамгаалж эхлэв

Зүүн өмнөд Азийн орнууд валютын ханшийн уналттай нүүр туллаа

◀1

Эдийн засгийн өсөлтөөрөө цахиур хагалж буй Филиппин, Индонез, Малайз, Тайланд улс мөнгөний бодлогоо өөрчилж, сүүлийн хэдэн жил харагдаагүй зоримог алхам хэрэгжүүлж байна. Нэг бүс нутагт хамаарах хөгжиж буй эдгээр улс валютын ханшаа хамгаалж, мөнгөний гадагшлах урсгалыг тогтоон барих хүндэн сорилттой тулгарууд байна. Тиймээс үүний эсрэг шил шилээ даран хариу арга хэмжээ авч эхэллээ.

ФИЛИППИН

Инфляцын түвшин

- Зорилтот 2-4 хувь
- Одоогийн 5.2 хувь

Филиппиний төв банк үнийн өсөлт, мөнгөн тэмдэгтийн уналттай нүүр тулчихаад байна. Тус улсын төв банк багаар бодоход хоёр, өслөө гэхэд дөрвөн хувьд барихаар төлөвлөсөн инфляцын түвшин нь өдгөө 5.2 хувь хүртлээ өссөн. Инфляц ийн төлөвлөсөөс ахихтай зэрэгцээд тус улсын мөнгөн тэмдэг болох песогийн ханш суларч, он гарснаас хойших хамгийн огцом суларсан мөнгөн тэмдэгтийн нэгд тооцогдож байна. Тиймээс мөнгөн тэмдэгтийн ханшаа хамгаалахын тулд Филиппиний төв банк өнгөрсөн сарын 20-нд бодлогын хүүгээ 0.25 нэгжээр өсгөж, 3.5 хувьд хүргэсэн байна. Хэдийгээр тус улсын инфляцын хүлээлт 2019 оны зорилтот түвшинд хүрэх төлөвтэй байгаа ч энэ онд улам өсөх магадгүй байгаа ажээ. Цаашид санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахын тулд бодлогын арга хэмжээ авахад бэлэн хэмээн тус улсын төв банкнаас мэдэгдсэн байна.

ИНДОНЕЗ

Инфляцын түвшин

- Зорилтот 2.5-4.5 хувь
- Одоогийн түвшин 3.12 хувь

Рупигээ хамгаалахаар Индонезийн төв банк туйлын зоригтой алхам хийж буйг шинжээчид онцолж байна. Учир нь тус улсын төв банк тавдугаар сараас хойш гурван удаа бодлогын хүүгээ хөндөөд байгаа юм. Өнгөрсөн сард гэхэд бодлогын жишиг хүүгээ 0.5 нэгжээр өсгөж, 5.25 нэгжид хүргэлээ. Валютын гадагшлах урсгалыг бууруулж, мөнгөн тэмдэгтийн ханшийн уналтыг тогтворжуулах шаардлага зүй ёсоор үүссэн. Тиймээс дотоодын санхүүгийн

ТАЙЛАНД

Инфляцын түвшин

- Зорилтот 1-4 хувь
- Одоогийн 1.38 хувь

Индонез, Филиппин мөнгөний бодлогоо эрс чангалж хэлсэн бол Тайландын төв банк бодлогын хүүгээ өсгөхөд бэлэн байна. Тус улсын төв банкны бодлого тодорхойлогчид бодлогын хүүг өнгөрсөн сарын 20-нд 1.5 хувьд хадгалсан ч дэлхийн эдийн засгийн өөрчлөлт, шилжилтийг дагана гэдгээ мэдэгджээ. Дайран дээр давс гэгчээр Тайландын багын ханш ам.долларын 1.6 хувиар суларсан. Мөн өнгөрсөн сард тус улсын инфляцын өсөлт саарсан ч цаашид нэмэгдэх хандлагатай байна. Томоохон орнуудын худалдаа болон мөнгөний бодлогын өөрчлөлт хөгжиж буй орнуудад эрсдэл дагуулж мэдэхээр байгаа бөгөөд цаашид ам.долларын ханш чангарах төлөвтэй байна. Тиймээс валютын ханшийг хамгаалж, багын үнийн эдийн засагт үзүүлэх үр нөлөөг илүү нарийн ажиглана гэж мэдэгдээд байна.

МАЛАЙЗ


Тэгвэл Малайзын төв банк өнгөрсөн долоо хоногт мөнгөний бодлогын жишиг хүүгээ 3.25 хувьд хадгаллаа. Ийнхүү




Эдийн засгийн өсөлтөөрөө цахиур хагалж буй Филиппин, Индонез, Малайз, Тайланд зэрэг улс мөнгөний бодлогоо өөрчилж, сүүлийн хэдэн жил харагдаагүй зоримог алхам хэрэгжүүлж байна.

зах зээлийн өрсөлдөх чадварыг хадгалж, олон улсад үүсээд буй тодорхойгүй байдлыг даван туулахын тулд ийнхүү бодлогын чиглэлээ эрс өөрчилсөн хэмээн тус улсын төв банкнаас мэдэгдээд байна. Хэрэв богино хугацаанд тус улсын мөнгөн тэмдэгтийн ханш тогтвортой байвал цаашид ч бодлогын хүүгээ өсгөнө гэж Bloomberg-ийн шинжээчид үзэж байгаа юм.


Монгол Улсын бодлогын хүү (хувиар)



Индонезийн бодлогын хүү (хувиар)



Филиппиний бодлогын хүү (хувиар)



харзсан бодлого хэрэгжүүлж байгаа ч улс төрийн хүрээнд өөрчлөлт өрсөсөн нь мөнгө болон санхүүгийн зах зээлд тодорхойгүй байдал дагуулаад байна. Учир нь тус улсын эрх баригч нам солигдсоны улмаас мөнгөний бодлого тодорхойлогчдыг шинээр

томилж хүлээлттэй байгаа юм. Малайзын инфляцын түвшин өдгөө 1.8 хувь байгаа. Гэхдээ тус улсын бодлого тодорхойлогчид хэрэглээний үнийн индекст төдийлэн ач холбогдол өгөхгүй буйгаа мэдэгдсэн. Учир нь газрын тосны ханшийн өсөлт

зарим талаар эерэг нөлөө үзүүлж байгаа аж. Түүнчлэн бараа, үйлчилгээний татварыг бууруулсан нь инфляцын дарамт энэ оны эцэс гэхэд багасна гэж тус улсын албаныхан үзэж байна. Гэхдээ хөрөнгийн гадагш урсгал болон валютын ханшийн уналтыг тогтоохын тулд бодлогын арга хэмжээ авахад бэлэн гэдгээ Малайзын төв банк мэдэгджээ.

МОНГОЛ

Инфляцын түвшин

- Зорилтот 8
- Одоогийн (2018.5) 6.1

Эдийн засгаа тэтгэж, бизнес идэвхжлийг дэмжихийн тулд сүүлийн жилүүдэд мөнгөний зөөлөн бодлого баримталж ирсэн Зүүн өмнөд Азийн хөгжиж буй орнууд валютын ханш хамгаалах аянд нэгдлээ. Тэгвэл төгрөгийн ханш суларч эхэлсэн энэ үед Монголбанк харьцангуй харзсан бодлого хэрэгжүүлж байгаа. Зургадугаар сарын 15-нд төв банкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалж, иргэдийн хэрэглээний зээлийн өр-орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоох шийдвэр гаргасан юм. Ирэх саруудад эдийн засгийн идэвхжил илүү нэмэгдэнэ. Энэ хэрээр инфляци дунд хугацаанд зорилтот найман хувийн орчимд тогтворжих төлөвтэй байгаа аж. Харин сүүлийн нэг жилийн хугацаанд харьцангуй тогтвортой байсан ам.доллартай харьцах төгрөгийн ханш эргэн суларч, 2460 нэгжид хэлбэлзэж байна. Хэдийгээр манай улсын экспорт нэмэгдэж байгаа ч үүнийг даган импорт өсөж буй нь төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна гэж төв банкнаас үзэж буй юм. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**
Монголын хөрөнгийн биржийн арилжаанд гар утаснаасаа оролцох боломжтой боллоо. Биржээс зах зээлийг идэвхжүүлэх, сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд зах зээлийн "IPO систем"-ийн API-ийг хөгжүүлжээ. Ингэснээр анхдагч зах зээлийн захиалгыг илүү хялбараар, хэрэглэгчдэд энгийн байдлаар нэвтрүүлэх боломжийг программ хангамжийн компаниудад олгож байна.

» **БАНК, САНХҮҮ**
Олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний Fitch агентлаг Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В-" байсныг "В" болгон дээшлүүлж, төлөвийг "Тогтвортой" болгов.

» УУЛ УУРХАЙ

1.1
Сая тонн. Улсын хэмжээнд энэ онд нийт 8.1 сая баррель буюу 1.1 сая тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байна.

» МОНГОЛБАНК

3.3
Сая ам.доллар. Монгол Улсын гадаад валютын нөөц 3.3 сая ам.доллартай хүрч, 2017 оны эхэн үетэй харьцуулахад гурав дахин нэмэгдсэн байна.

» БИЗНЕСИЙН ОРЧИН

158.8
